



МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН
ДААТГАЛЫН ТӨСӨЛ



МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН 2007 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ТАЙЛАН

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

**УЛААНБААТАР ХОТ
2007 он**



I. МИД-ын 2007 оны борлуулалтын улиралд хийн гүйцэтгэсэн ажлуудын жагсаалт

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан МИД-ын “Хөгжлийн зээлийн гэрээ”, “Төсөл хэрэгжүүлэх заавар”, ажлын төлөвлөгөөний дагуу МИД-ын 2007 оны борлуулалтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Хүснэгт №1. 2007 борлуулалтын улирлын үйл явц

Огноо	Үйл ажиллагаа
2006 оны 9-р сар	<ul style="list-style-type: none">Дотоодын даатгалын компаниудад МИД-ын талаар сургалт зохион байгуулж, төслийн үйл ажиллагаа, төсөлд оролцох шаардлагыг танилцуулсан.МИД-ын хэрэгжилт, цаашдын хандлагыг оролцогч талууд, хууль тогтоогч байгууллагатай хэлэлцэх зөвлөлдөн уулзалтыг зохион байгуулсан.
11-12-р сар	<ul style="list-style-type: none">МИД-ын 2007 оны борлуулалтын улиралд хийх өөрчлөлтүүдийг тодорхойлсон.ҮДБ-ний 6 болон 10 хувийн босго үзүүлэлттэй бүтээгдэхүүний хураамжийн хувь хэмжээг тодорхойлсон.МИД төслийн програм хангамжийн 2007 оны хувилбарыг боловсруулж эхэлсэн.МИД-ын 2007 оны борлуулалтын улиралд оролцох даатгалын компаниудыг сонгон шалгаруулсан.
2007 оны 1-р сар	<ul style="list-style-type: none">МИД-ын програм хангамжийн 2006 оны хувилбарыг хаан, 2006 оны борлуулалтын мэдээллийн санг битүүмжилсэн.МИД-ын зарчим, үйл ажиллагааны талаарх даатгалын компанийн сургагч багш, сумдын ажилтнууд, даатгалын төлөөлөгчид, орон нутгийн удирдлагуудад зориулсан гарын авлагыг шинэчлэн боловсруулсан.Даатгалын компанийн сургагч багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулсан.
2-р сар	<ul style="list-style-type: none">Оролцогч даатгалын компаниудтай МИД-ын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан.ҮДБ-ний стандарт гэрээг шинэчлэн боловсруулсан.ГХБ-нд хамруулах журмыг шинэчлэн боловсруулсан.МИД-ын 2007 оны борлуулалтын улиралд ашиглагдах даатгалын баталгааны маягт, гэрчилгээ, дардасын загварыг боловсруулан хэвлэсэн.Даатгалын төлөөлөгчид эрх олгох шалгалтыг ТХН, СЯ, СЗХ-ны төлөөлөлтэйгээр зохион байгуулж, 153 төлөөлөгчид эрх олгосон.Даатгалын компаниудад баталгааны маягт, гэрчилгээ, дардасыг хүлээлгэн өгч борлуулалтын улирал эхлэх бэлтгэл хангасан.
3-р сар	<ul style="list-style-type: none">Зурагт хуудас, нугалбар, даатгагчдад зориулсан товхимол, сонин зэрэг хэвлэмэл сурталчилгааны материалуудад хэвлэж тараасан.МИД-ын 2007 оны борлуулалтад оролцогч даатгалын компаниуд БНТХ-ыг ТХН-ийн дансанд байршуулсан.МИД-ын нөөцийн сангуудад хүү тооцох талаар ХААН Банктай гэрээ байгуулсан.МИД-ын борлуулалтын улирал нээгдэж, даатгалын төлөөлөгчид орон нутагт борлуулалтын үйл ажиллагаагаа эхэлсэн.Борлуулалтын улирал эхэлсэнтэй холбогдуулан ТХН-ийн ажилтнууд, даатгалын компани, даатгалын төлөөлөгчдийн үйл ажиллагаатай




	<p>танилцаж, зөвлөгөө өгсөн.</p> <ul style="list-style-type: none">• МИД-ын програм хангамжийн 2007 оны хувилбар боловсруулагдсан.
4-р сар	<ul style="list-style-type: none">• МИД-ын борлуулалтыг бүртгэх програм хангамжийг туршилтын аймгууд дахь даатгалын компани болон ТХН-д суурилуулсан.• Нүүр тулсан сургалт орон нутагт явагдаж эхэлсэн.• Туршилтын аймгуудын сум тус бүрийн ХААН Банкны салбар нэгжид МИД-ын 2007 оны хураамжийн орлого төвлөрөх данс нээгдсэн.
5-р сар	<ul style="list-style-type: none">• Хагас жилийн мал тооллого сонгогдсон 3 аймагт явагдсан.
6-р сар	<ul style="list-style-type: none">• Дэлхийн Банкны ажлын хэсэг МИД-ын 2007 оны борлуулалтын явцтай танилцсан.• 2007 оны хагас жилийн мал тооллого, Туршилтын түүвэр судалгааны дүн мэдээг нэгтгэн боловсруулсан.
7-р сар	<ul style="list-style-type: none">• МИД-д 2006 онд даатгуулсан малчдад олгох нөхөн төлбөрийн тооцооллыг төслийн програм хангамж ашиглан хийсэн.• МИД-ын 2006 оны үр дүнг тооцоолж, МДНТ-ийн дансыг хаан 2006 онд оролцсон даатгалын компаниудад үлдэгдэл хөрөнгийг хувиарласан.• Туршилтын аймгуудад ажиллан МИД-ын 2007 борлуулалтын улирлыг хаасан.• Орон нутаг дахь даатгалын компаниудын борлуулалтын мэдээллийн санг битүүмжлэн програм хангамжийг хаасан.
8-р сар	<ul style="list-style-type: none">• 2006 онд МИД-д хамрагдсан малчдад нөхөн төлбөрийг шилжүүлэн олгосон.• МИД-ын 2007 оны хураамжийн орлогыг татан төвлөрүүлсэн.
9-р сар	<ul style="list-style-type: none">• Оролцогч даатгалын компаниудтай МИД-ын 2007 оны борлуулалтыг тулгах, БНТХ-ын бодит хэмжээг тодорхойлох ажил явагдаж байна.



II. МИД-ын 2007 оны борлуулалт

МИД-ын хоёрдахь борлуулалтын улирал 2007 оны 3-р сарын 15-нд туршилтын Увс, Хэнтий, Баянхонгор аймгийн нийт 56 сумдад эхэлснээс хойш 2007 оны 7-р сарын 10 хүртэлх хугацаанд төсөлд орлцогч даатгалын компаниуд нийт 3705 малчинтай МИД-ын ҮДБ болон ГХБ-ний гэрээг байгуулж, 129,047,464 төгрөгийн борлуулалт хийгдсэн. Энэ нь 2006 оны борлуулалттай харьцуулахад борлуулалтын орлого 50 хувиар, даатгуулагчдын тоо 65 хувиар өссөн дүн юм.

График №1. МИД-ын борлуулалтын орлого



2006 оны эцсийн байдлаар сонгогдсон 3 аймагт нийт 28746 малчин өрх байгаагаас 3705 өрх буюу 12,8 хувь нь даатгалд хармрагджээ. Түүнчлэн 3 аймгийн хувьд нийт 589578 толгой мал МИД-д хамрагдсан нь 2006 оны мөн үзүүлэлтээс 100 хувиар өссөн ба 3 аймгийн 6,17 сая малын 9,5 хувийг эзэлж байна.

Хүснэгт №2. МИД-д хамрагдсан малын тоо

Аймаг	ҮДБ-д хамрагдсан малын тоо (толгой)					Нийт	ГХБ-д хамрагдсан малын тоо (толгой)					Нийт
	Үхэр	Хонь	Ямаа	Адуу	Тэмээ		Үхэр	Хонь	Ямаа	Адуу	Тэмээ	
Баянхонгор	9607	35352	80329	5200	36	238708	3404	31478	67974	5028	300	108187
Увс	3385	42449	73630	1574	19	145952	2429	8613	12300	1353	200	24937
Хэнтий	7343	9807	13478	5590	0	54006	3298	7125	5433	1932	0	17788
Дүн	20335	87608	167437	12364	55	438666	9131	47216	85707	8313	500	150912

Баянхонгор аймаг

Баянхонгор аймгийн хувьд нийт 1708 малчин даатгалд хамрагдсан нь туршилтын аймгуудаас хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд тус аймгийн малчин өрхийн 14,7 хувь, малтай өрхийн 12,5 хувь, 2007 онд МИД-д хамрагдсан малчдын 46,1 хувь болж байна. Баянхонгор аймагт Бодь Даатгал, Монгол Даатгал, Түшиг Даатгал компаниуд борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж нийт 75.6 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь МИД-ын 2007 оны борлуулалтын орлогын 58,6 хувийг бүрдүүлж байна.

**Хүснэгт №3. Даатгуулагчдын тоо ба борлуулалтын нийт хэмжээ (Баянхонгор аймаг)**

№	Сум	Бодь Даатгал		Монгол Даатгал		Түшиг Даатгал		Нийт дүн	
		Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо
1	Баянхонгор	952,262	13	188,918	2	1,145,106	8	2,286,286	23
2	Баацагаан	1,088,101	42	362,292	11	-	-	1,450,393	53
3	Баянбулаг	-	-	2,634,333	42	-	-	2,634,333	42
4	Баянговь	-	-	469,220	17	1,279,216	41	1,748,436	58
5	Баянлиг	995,200	34	174,216	5	-	-	1,169,416	39
6	Баян-Овоо	367,974	10	2,531,216	51	-	-	2,899,190	61
7	Баян-Өндөр	-	-	679,700	11	2,530,220	43	3,209,920	54
8	Баянцагаан	1,377,956	27	2,632,870	61	-	-	4,010,826	88
9	Богд	-	-	2,273,694	79	308,700	12	2,582,394	91
10	Бөмбөгөр	1,979,960	51	2,272,200	89	920,280	28	5,172,440	168
11	Бууцагаан	-	-	1,422,882	26	3,738,752	56	5,161,634	82
12	Галуут	544,516	12	1,521,256	30	4,483,108	164	6,548,880	206
13	Гурванбулаг	-	-	1,335,455	38	434,374	21	1,769,829	59
14	Жаргалант	-	-	3,527,036	70	938,421	17	4,465,457	87
15	Жинст	-	-	512,719	26	67,440	5	580,159	31
16	Заг	-	-	3,765,388	53	-	-	3,765,388	53
17	Өлзийт	1,124,175	25	4,905,764	102	908,711	22	6,938,650	149
18	Хүрээмарал	-	-	1,719,730	49	9,871,922	147	11,591,652	196
19	Шинэжинст	648,760	37	-	-	2,671,250	64	3,320,010	101
20	Эрдэнэцогт	500,500	7	-	-	3,861,395	60	4,361,895	67
	Нийт	9,579,404	258	32,928,889	762	33,158,895	688	75,667,187	1,708

Хүснэгт №4. ҮДБ ба ГХБ-ний борлуулалтын орлого (Баянхонгор аймаг)

№	Сум	Бодь Даатгал		Монгол Даатгал		Түшиг Даатгал		Нийт дүн	
		ҮДБ	ГХБ	ҮДБ	ГХБ	ҮДБ	ГХБ	ҮДБ	ГХБ
1	Баянхонгор	952,262	-	188,918	-	1,145,106	-	2,286,286	-
2	Баацагаан	1,026,101	62,000	362,052	240	-	-	1,388,153	62,240
3	Баянбулаг	-	-	2,502,933	131,400	-	-	2,502,933	131,400
4	Баянговь	-	-	464,220	5,000	1,157,016	122,200	1,621,236	127,200
5	Баянлиг	779,040	216,160	174,216	-	-	-	953,256	216,160
6	Баян-Овоо	339,494	28,480	2,431,456	99,760	-	-	2,770,950	128,240
7	Баян-Өндөр	-	-	679,500	200	2,490,180	40,040	3,169,680	40,240
8	Баянцагаан	1,348,316	29,640	2,624,990	7,880	-	-	3,973,306	37,520
9	Богд	-	-	2,026,574	247,120	277,500	31,200	2,304,074	278,320
10	Бөмбөгөр	1,937,720	42,240	2,141,040	131,160	882,840	37,440	4,961,600	210,840
11	Бууцагаан	-	-	1,414,882	8,000	3,631,352	107,400	5,046,234	115,400
12	Галуут	530,756	13,760	1,440,136	81,120	3,332,068	1,151,040	5,302,960	1,245,920
13	Гурванбулаг	-	-	1,187,735	147,720	422,614	11,760	1,610,349	159,480
14	Жаргалант	-	-	3,350,476	176,560	926,021	12,400	4,276,497	188,960
15	Жинст	-	-	429,759	82,960	54,720	12,720	484,479	95,680
16	Заг	-	-	3,533,188	232,200	-	-	3,533,188	232,200
17	Өлзийт	1,014,255	109,920	4,642,684	263,080	858,871	49,840	6,515,810	422,840
18	Хүрээмарал	-	-	1,451,890	267,840	9,006,602	865,320	10,458,492	1,133,160
19	Шинэжинст	544,400	104,360	-	-	2,430,050	241,200	2,974,450	345,560
20	Эрдэнэцогт	496,500	4,000	-	-	3,837,395	24,000	4,333,895	28,000
	Нийт	8,968,844	610,560	31,046,649	1,882,240	30,452,335	2,706,560	70,467,827	5,199,360

Тус аймгийн хэмжээнд нийт 238708 толгой малыг ҮДБ-д, 108187 толгой малыг ГХБ-д хамруулсан. Баянхонгор аймгийн нийт малтай харьцуулахад ҮДБ-д даатгагдсан мал 12,7 хувь, ГХБ-д хамрагдсан мал 5,7 хувийг эзэлж байна.



Өмнөх онтой харьцуулахад борлуулалтын орлого 72 хувь буюу 26,7 сая төгрөгөөр өссөн нь:

1. Даатгуулагчдын тоо өссөн (761 хүнээр буюу 80,3 хувиар)
2. Нэгж даатгуулагчийн төлөх хураамжийн хэмжээ өссөнтэй (46082 төгрөгөөс 52854 төгрөг болсон) холбоотой юм.

2007 онд МИД-д хамрагдсан малчдын тоо өмнөх онтой харьцуулахад Баянхонгор болон Баянбулаг сумаас бусад сумын хувьд өссөн байна. Түүнчлэн өмнөх онтой харьцуулахад нийт борлуулалтад эзлэх ГХБ-ний хэмжээ 3 хувиас 7 хувь болтлоо өссөн байна.

Баянхонгор аймагт Бодь Даатгал компанийн 10, Монгол Даатгал компанийн 20, Түшиг Даатгал компанийн 19 төлөөлөгч ажилласан.

Увс аймаг

Увс аймгийн хувьд нийт 1431 малчин МИД-д хамрагдсан нь аймгийн нийт малчдын 14,2 хувь, малтай өрхийн 10,2 хувь, 2007 онд МИД-д хамрагдсан малчдын 38,6 хувийг эзэлж байна. Борлуулалтын орлого 27,4 сая төгрөг болсон нь МИД-ын 2007 оны борлуулалтын 21,2 хувийг бүрдүүлж байна.

Увс аймгийн хэмжээнд нийт 145952 толгой малыг ҮДБ-д, 24937 толгой малыг ГХБ-д хамруулсан. Увс аймгийн нийт малтай харьцуулахад ҮДБ-д даатгагдсан мал 6,1 хувь, ГХБ-д хамрагдсан мал 1,0 хувийг эзэлж байна.

Тус аймгийн хувьд даатгуулагчдын тоо нь өмнөх жилийнхээс 247 хүнээр өссөн боловч даатгалын хураамжийн хэмжээ 2 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь:

1. Нийт борлуулалтад эзлэх ГХБ-ний хэмжээ өссөн (2 хувиас 5 хувь болсон)
2. Нэгж даатгуулагчийн төлөх хураамжийн хэмжээ багассантай (25065 төгрөгөөс 19172 төгрөг болсон)
3. Монгол Даатгал болон Прайм Даатгал компаниудын байгуулсан даатгалын гэрээ өмнөх оныхоос багассантай холбоотой байна.

Зүүнговь, Өлгий, Тариалан, Тэс зэрэг сумдын даатгуулагчдын тоо өмнөх оныхоос буурсан байна.

Хүснэгт №5. Даатгуулагчдын тоо ба борлуулалтын нийт хэмжээ (Увс аймаг)

№	Сум	Бодь Даатгал		Монгол Даатгал		Прайм Даатгал		Түшиг Даатгал		Нийт дүн	
		Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо
1	Улаангом	227,330	23	-	-	427,304	35	176,638	18	831,272	76
2	Баруунтуруун	350,392	20	-	-	236,197	19	14,900	4	601,489	43
3	Бөхмөрөн	344,445	25	-	-	265,050	20	114,800	3	724,295	48
4	Давст	-	-	-	-	77,196	13	637,161	48	714,357	61
5	Завхан	1,713,404	30	412,370	6	437,740	6	1,011,204	30	3,574,718	72
6	Зүүнговь	-	-	393,976	13	599,008	30	785,164	48	1,778,148	91
7	Зүүнхангай	-	-	458,064	24	785,728	30	-	-	1,243,792	54
8	Малчин	834,554	50	614,575	32	585,023	41	386,900	14	2,421,052	137
9	Наранбулаг	467,510	25	1,442,120	40	1,508,975	61	-	-	3,418,605	126
10	Өлгий	202,600	5	-	-	220,450	17	290,538	30	713,588	52
11	Өмнөговь	994,039	50	824,938	47	925,271	53	-	-	2,744,248	150
12	Өндөрхангай	-	-	-	-	738,674	37	1,014,208	62	1,752,882	99
13	Сагил	57,519	2	-	-	507,328	21	90,000	1	654,847	24
14	Тариалан	-	-	451,181	24	162,491	35	87,660	7	701,332	66
15	Түргэн	-	-	75,000	2	574,022	20	319,723	15	968,745	37
16	Тэс	-	-	-	-	154,645	20	106,630	50	261,275	70
17	Ховд	1,517,200	40	-	-	753,660	30	-	-	2,270,860	70
18	Хяргас	376,880	22	29,920	23	318,040	30	291,980	20	1,016,820	95
19	Цагаанхайрхан	337,523	19	218,316	12	493,755	29	-	-	1,049,594	60
	Нийт	7,423,396	311	4,920,460	223	9,770,557	547	5,327,506	350	27,441,919	1,431

**Хүснэгт №6. ҮДБ ба ГХБ-ний борлуулалтын орлого (Увс аймаг)**

№	Сум	Бодь Даатгал		Монгол Даатгал		Прайм Даатгал		Түшиг Даатгал		Нийт дүн	
		ҮДБ	ГХБ	ҮДБ	ГХБ	ҮДБ	ГХБ	ҮДБ	ГХБ	ҮДБ	ГХБ
1	Улаангом	217,650	9,680			418,384	8,920	168,878	7,760	804,912	26,360
2	Баруунтуруун	346,792	3,600			213,517	22,680	10,700	4,200	571,009	30,480
3	Бөхмөрөн	344,445	-			265,050	-	101,200	13,600	710,695	13,600
4	Давст					77,196	-	629,001	8,160	706,197	8,160
5	Завхан	1,647,684	65,720	412,370	-	376,020	61,720	996,684	14,520	3,432,758	141,960
6	Зүүнговь			387,576	6,400	571,648	27,360	717,644	67,520	1,676,868	101,280
7	Зүүнхангай			432,504	25,560	767,448	18,280			1,199,952	43,840
8	Малчин	834,554	-	614,575	-	551,503	33,520	384,900	2,000	2,385,532	35,520
9	Наранбулаг	431,150	36,360	1,392,640	49,480	1,360,775	148,200			3,184,565	234,040
10	Өлгий	200,000	2,600			116,610	103,840	184,418	106,120	501,028	212,560
11	Өмнөговь	965,199	28,840	763,938	61,000	925,271	-			2,654,408	89,840
12	Өндөрхангай					730,034	8,640	952,928	61,280	1,682,962	69,920
13	Сагил	57,519	-			450,448	56,880	90,000	-	597,967	56,880
14	Тариалан			399,221	51,960	124,931	37,560	87,660	-	611,812	89,520
15	Түргэн			75,000	-	574,022	-	284,403	35,320	933,425	35,320
16	Тэс					154,645	-	80,550	26,080	235,195	26,080
17	Ховд	1,466,680	50,520			747,260	6,400			2,213,940	56,920
18	Хяргас	364,200	12,680	-	29,920	285,840	32,200	201,940	90,040	851,980	164,840
19	Цагаанхайрхан	337,523	-	218,316	-	488,155	5,600			1,043,994	5,600
	Нийт	7,213,396	210,000	4,696,140	224,320	9,198,757	571,800	4,890,906	436,600	25,999,199	1,442,720

Увс аймагт Бодь Даатгал компанийн 18, Монгол Даатгал компанийн 12, Прайм Даатгал компанийн 16, Түшиг Даатгал компанийн 14 төлөөлөгч ажилласан.

Хэнтий аймаг

Хэнтий аймгийн хувьд нийт 566 малчин МИД-д хамрагдсан бөгөөд аймгийн нийт малчдын 7,9 хувь, малтай өрхийн 6,2 хувь, 2007 онд МИД-д хамрагдсан малчдын 15,3 хувийг эзэлж байна. Борлуулалтын орлого 25,9 сая төгрөг болсон нь МИД-ын 2007 оны борлуулалтын 20,1 хувийг бүрдүүлж байна.

Тус аймгийн хэмжээнд нийт 54006 толгой малыг ҮДБ-д, 17788 толгой малыг ГХБ-д хамруулсан. Хэнтий аймгийн нийт малтай харьцуулахад ҮДБ-д даатгагдсан мал 2,8 хувь, ГХБ-д хамрагдсан мал 0,9 хувийг эзэлж байна.

Даатгуулагчдын тоо 288 хүн буюу 103 хувиар өссөн, борлуулалтын орлого 13 сая төгрөг буюу 101 хувиар өссөн байна.

Хүснэгт №7. Даатгуулагчдын тоо ба борлуулалтын нийт хэмжээ (Хэнтий аймаг)

№	Сум	Бодь Даатгал		Монгол Даатгал		Прайм Даатгал		Түшиг Даатгал		Нийт дүн	
		Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо	Борлуулалтын орлого	Даатгуулагчдын тоо
1	Хэрлэн	33,000	1	1,208,555	6	440,332	16	68,450	5	1,750,337	28
2	Батноров	-	-	1,248,234	24	187,400	5	22,600	2	1,458,234	31
3	Батширээт	-	-	866,159	20	153,542	4	28,080	1	1,047,781	25
4	Баян-Адрага	-	-	680,208	23	904,633	37	-	-	1,584,841	60
5	Баянмөнх	-	-	204,540	2	993,944	18	256,750	4	1,455,234	24
6	Баян-Овоо	310,308	4	170,636	4	401,616	3	1,407,440	26	2,290,000	37
7	Баянхутаг	677,576	8	957,932	12	-	-	1,764,456	24	3,399,964	44
8	Биндэр	577,058	12	33,176	3	134,928	6	-	-	745,162	21
9	Галшар	-	-	1,121,776	14	671,264	32	-	-	1,793,040	46
10	Дадал	-	-	46,376	2	478,850	11	-	-	525,226	13
11	Дархан	-	-	1,428,894	36	378,712	15	16,250	1	1,823,856	52
12	Дэлгэрхаан	65,980	2	184,320	7	545,541	14	-	-	795,841	23
13	Жаргалтхаан	-	-	249,240	5	193,400	7	658,780	8	1,101,420	20
14	Мөрөн	179,592	3	972,000	20	-	-	315,036	14	1,466,628	37
15	Норовлин	-	-	691,400	8	-	-	487,538	17	1,178,938	25
16	Өмнөдэлгэр	36,120	2	-	-	323,976	8	280,920	11	641,016	21
17	Цэнхэрмандал	-	-	1,718,752	29	-	-	1,162,088	30	2,880,840	59
	Нийт	1,879,634	32	11,782,198	215	5,808,138	176	6,468,388	143	25,938,358	566



Даатгуулагчдын төлсөн дундаж хураамжийн хэмжээ 46253 төгрөгөөс 45827 төгрөг болж өөрчлөгджээ. Түүнчлэн нийт борлуулалтад эзлэх ГХБ-ний хэмжээ 3 хувиас 5 хувь болж нэмэгджээ.

Хүснэгт №8. ҮДБ ба ГХБ-ний борлуулалтын орлого (Хэнтий аймаг)


№	Сум	Бодь Даатгал		Монгол Даатгал		Прайм Даатгал		Түшиг Даатгал		Нийт дүн	
		ҮДБ	ГХБ	ҮДБ	ГХБ	ҮДБ	ГХБ	ҮДБ	ГХБ	ҮДБ	ГХБ
1	Хэрлэн	33,000	-	1,208,555	-	426,372	13,960	57,690	10,760	1,725,617	24,720
2	Батноров			1,196,914	51,320	179,400	8,000	21,000	1,600	1,397,314	60,920
3	Батширээт			858,959	7,200	144,102	9,440	28,080	-	1,031,141	16,640
4	Баян-Адрага			568,048	112,160	777,273	127,360			1,345,321	239,520
5	Баянмөнх			204,540	-	975,824	18,120	238,830	17,920	1,419,194	36,040
6	Баян-Овоо	310,308	-	170,636	-	401,616	-	1,407,440	-	2,290,000	-
7	Баянхутаг	677,576	-	936,252	21,680			1,756,456	8,000	3,370,284	29,680
8	Биндэр	577,058	-	26,136	7,040	134,928	-			738,122	7,040
9	Галшар			1,121,776	-	561,344	109,920			1,683,120	109,920
10	Дадал			46,376	-	478,850	-			525,226	-
11	Дархан			1,330,614	98,280	268,272	110,440	16,250	-	1,615,136	208,720
12	Дэлгэрхаан	65,980	-	115,800	68,520	433,461	112,080			615,241	180,600
13	Жаргалтхаан			249,240	-	169,800	23,600	643,500	15,280	1,062,540	38,880
14	Мөрөн	179,592	-	918,280	53,720			307,036	8,000	1,404,908	61,720
15	Норовлин			691,400	-			392,978	94,560	1,084,378	94,560
16	Өмнөдэлгэр	36,120	-			321,576	2,400	265,200	15,720	622,896	18,120
17	Цэнхэрмандал			1,718,752	-			1,027,328	134,760	2,746,080	134,760
	Нийт	1,879,634	-	11,362,278	419,920	5,272,818	535,320	6,161,788	306,600	24,676,518	1,261,840

Тус аймгийн Баян-Овоо сумаас бусад бүх сумдад даатгуулагчдын тоо өссөн бөгөөд Баян-Овоо сумын хувьд өмнөх жилийн үзүүлэлттэй адил байна.

Хэнтий аймагт Бодь Даатгал компанийн 9, Монгол Даатгал компанийн 14, Прайм Даатгал компанийн 13, Түшиг Даатгал компанийн 12 төлөөлөгч ажилласан.

Туршилтын 3 аймгийн хувьд 2007 онд даатгалд хамрагдсан малын 34 хувийг ямаа, 34 хувийг үхэр, 21 хувийг хонь, 11 хувийг адуу, 0,01 хувийг тэмээн сүрэг эзэлж байна. Даатгалд хамрагдсан малын бүтцийг дараах графикт үзүүлэв.

График №2. МИД-д хамрагдсан малын бүтэц



Өмнөх жилтэй харьцуулахад даатгуулсан малын бүтцэд ямааны эзлэх хувь 3 пунктээр, хонины эзлэх хувь 2 пунктээр, адууны эзлэх хувь 1 пунктээр буурч, үхэр сүргийн эзлэх хувь 4 пунктээр өссөн байна.



III. Даатгалын компани

Бодь Даатгал компани 37, Монгол Даатгал компани 46, Прайм Даатгал компани 29, Түшиг Даатгал компани 45 эрх бүхий даатгалын төлөөлөгчидтэйгээр туршилтын аймгуудад МИД-ын 2007 оны борлуулалтыг гүйцэтгэсэн. Ерөнхийдөө 2006 онтой харьцуулахад даатгалын компаниуд “чанартай” цөөн тооны төлөөлөгчидтэй ажиллах сонирхолтой байсан нь ажиглагдсан.

Өмнөх жилд нэгж даатгалын төлөөлөгчид Баянхонгор аймгийн хувьд 24, Увс аймгийн хувьд 22, Хэнтий аймгийн хувьд 6 малчинтай гэрээ хийж байсан.

Даатгалын компаниуд	Баянхонгор аймаг		Увс аймаг		Хэнтий аймаг	
	Даатгуулагч дын тоо	Хураамжийн орлого	Даатгуулагч дын тоо	Хураамжийн орлого	Даатгуулагч дын тоо	Хураамжийн орлого
Монгол Даатгал	22	974,528	15	430177	11	564641
Прайм Даатгал	-		31	818689	3	138829
Түшиг Даатгал	26	1,233,079	21	401893	4	145921
Дундаж	24	1103803	22	550253	6	283130

Харин 2007 онд нэгж даатгалын төлөөлөгч Баянхонгор аймгийн хувьд 33, Увс аймгийн хувьд 24, Хэнтий аймгийн хувьд 11 малчинтай гэрээ хийх болжээ.

Даатгалын компаниуд	Баянхонгор аймаг		Увс аймаг		Хэнтий аймаг	
	Даатгуулагч дын тоо	Хураамжийн орлого	Даатгуулагч дын тоо	Хураамжийн орлого	Даатгуулагч дын тоо	Хураамжийн орлого
Бодь	26	957940	17	412113	4	208848
Монгол Даатгал	38	1645627	19	410038	15	841585
Прайм Даатгал			34	610660	11	446780
Түшиг Даатгал	36	1744329	25	380534	15	539032
Дундаж	33	1449299	24	453336	11	509061

МИД-ын 2007 оны борлуулалтын орлогын хэмжээг оролцогч даатгалын компани тус бүрээр харуулбал:

Хүснэгт №9. Даатгалын компаниудын борлуулалтын орлого

Даатгалын компаниуд	ҮДБ-ний борлуулалтын орлого		ГХБ-ний борлуулалтын орлого		Борлуулалтын нийт хэмжээ	
	/төгрөгөөр/	/хувиар/	/төгрөгөөр/	/хувиар/	/төгрөгөөр/	/хувиар/
Бодь Даатгал	18061873.5	14.91	820560	10.38	18882433.5	14.63
Монгол Даатгал	47105066.7	38.88	2526480	31.96	49631546.7	38.46
Прайм Даатгал	14471575	11.95	1107120	14.01	15578695	12.07
Түшиг Даатгал	41505029	34.26	3449760	43.65	44954789	34.84
Дүн	121143544	100.00	7903920	100.00	129047464	100.00

МИД-ын борлуулалт хийгдсэн малчдын тоо даатгалын компани тус бүрээр харуулбал:

Хүснэгт №10. Даатгалын компаниудын даатгуулагчдын тоо

Оролцогч даатгалын компаниуд	Баянхонгор аймаг		Увс аймаг		Хэнтий аймаг		Нийт	
	/тоо/	/хувиар/	/тоо/	/хувиар/	/тоо/	/хувиар/	/тоо/	/хувиар/
Бодь Даатгал	258	15.11%	311	21.73%	32	5.65%	601	16.22%
Монгол Даатгал	762	44.61%	223	15.58%	215	37.99%	1200	32.39%
Прайм Даатгал	-		547	38.23%	143	25.27%	690	18.62%
Түшиг Даатгал	688	40.28%	350	24.46%	176	31.10%	1214	32.77%
Дүн	1708	100.00%	1431	100.00%	566	100.00%	3705	100.00%

2006 онд МИД-ын нийт борлуулалтын орлогын 47,3 хувийг Монгол Даатгал компани, 35,3 хувийг Түшиг Даатгал компани, 22,1 хувийг Прайм Даатгал компани эзэлж байсан бол 2007 онд Монгол Даатгал компанийн эзлэх хувь буурч, Түшиг Даатгал компанийн эзлэх хувь



харьцангуйгаар тогтвортой байна. Бодь Даатгал компани 3 аймагт МИД-ын борлуулалтыг хийсэн боловч 2 аймагт үйл ажиллагаа явуулсан Прайм даатгалын компаниас бага орлого төвлөрүүлсэн нь тус компани шинээр орон нутагт ажиллаж байгаатай холбоотой гэж үзэж байна.

Хугацааны хувьд оролцогч даатгалын компаниудын борлуулалт 6-р сарын сүүлч 7-р сарын эхээр эрчимжсэн нь малчид байгаль цаг уурыг харзсан хүлээж байсантай холбоотой байлаа.

График №2. МИД-ын борлуулалтын хэмжээ (Хугацаагаар)

